

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлагдсан. Төлөвлөгөөний “Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд орон нутгийн эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлэх” Зорилго 2-ын хүрээнд 1, “Хүний хөгжлийн бодлогын хүрээнд өвчлөл, нас баралтыг бууруулах” Зорилго 3-ын хүрээнд 22, нийт 23 арга хэмжээг Эрүүл мэндийн яам үндсэн хэрэгжүүлэхээр батлагдсан.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийн түвшинг жилийн эцсийн байдлаар үнэлж, хэрэгжилт хангалтгүй үнэлэгдсэн арга хэмжээний бодит шалтгааныг тодруулах, зөвлөмж боловсруулах, шийдвэр гаргагчдыг бодит, нотолгоонд суурилсан мэдээллээр хангах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

Хоёр. Хяналт-шинжилгээ үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-д заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг журмын нэгдүгээр хавсралтын 6.1, 6.4 дэх заалтад заасан бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх аргачлалыг баримтлан хэрэгжилтийн хувиар тооцон дүгнэлээ.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан эрүүл мэндийн салбарын 23 арга хэмжээний хэрэгжилт 2025 оны жилийн эцсийн байдлаар 86.85 хувь, тэргүүлэх чиглэлийн 20 арга хэмжээний хэрэгжилт 73.26 хувьтай тус тус үнэлэгдлээ.

Жилийн эцсийн байдлаар “Үр дүнгүй” буюу 17–75 хувийн үнэлгээтэй 6 арга хэмжээ байна. Үүнд:

- 3.1.1.1 Эрүүл шүд арга хэмжээний (2024-2027) тухайн оны төлөвлөгөөт арга хэмжээний хэрэгжилт (41.7%, НЭМБХГ);
- 3.1.1.1 "Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх", "Эрүүл Монгол", "Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийн цогц арга хэмжээний тухайн оны төлөвлөгөөт арга хэмжээний хэрэгжилт (55.6%, НЭМБХГ);
- 3.1.2.3.Зүрх, судасны үндэсний төвийг барих (50.0%, СЭЗБХГ);
- 3.1.2.8.Монгол Улсад оношлогдох, эмчлэгдэх боломжгүй өвчний чиглэлээр технологи нэвтрүүлэх (60.0%, ЭТБХГ);
- 3.1.2.9.Эрүүл мэндийн байгууллагуудын автомашины парк шинэчлэлтийг хийх (17.0%, СЭЗБХГ);
- 3.1.3.2.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын хяналтын лавлагаа лабораторийн чадавхыг нэмэгдүүлэх (56.5%, СЭЗБХГ);

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлийн хүрээнд, “Үр дүнгүй” буюу 20–83.3 хувийн үнэлгээтэй 9 арга хэмжээ байна. Үүнд:

- 3.3.1.Эрүүл, идэвхтэй амьдралын зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэх бодлогын реформыг хэрэгжүүлнэ (50.0%,НЭМБХГ);
- 3.3.3.Газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зориулалттай Хуримтлалын сангаас иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээнд зориулан дэмжлэг үзүүлэх, эрх зүйн орчныг бүрдүүлнэ (20.0%, СЭЗБХГ);
- 3.3.5. Эрүүл мэндийн салбарын чанар, үр дүнд суурилсан гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоог сайжруулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авахад иргэнд учрах санхүүгийн дарамтыг бууруулах, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг эхлүүлнэ (60.0%, СЭЗБХГ);
- 3.3.6.Хүн амын дунд согтууруулах ундаа, тамхины хэрэглээг бууруулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх, ажлын байрны дотоод орчин, олон нийтийн газар, нийтийн тээвэрт иргэд дам тамхидалтад өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж, Тамхины хяналтын тухай хуулийг шинэчлэн боловсруулна (75.0%, НЭМБХГ);
- 3.3.9."Эрүүл шүд", "Хорт хавдраас сэргийлэх, хянах", зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх "Эрүүл Монгол" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ (52.2%, НЭМБХГ, ЭТБХГ);
- 3.3.11.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, орон нутгийн нэгдсэн эмнэлгийн чадавхыг бэхжүүлж, зарим тусламж, үйлчилгээний төвүүдийг төрөлжүүлэн байгуулна /Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв, Хавдар судлалын үндэсний төв-II, Халдварт өвчин судлалын үндэсний төв-II, Зүрх судасны үндэсний төв (83.3%, СЭЗБХГ);
- 3.3.17. Хүн амын бие бялдрын хөгжлийг хянах цахим технологи, өгөгдлийн системийг хөгжүүлж, нийтийн биеийн тамир, спортын орчны хүртээмжийг сайжруулна (50.0%, НЭМБХГ);
- 4.7.7. Олон нийтийг хамарсан халдварт өвчин, цар тахал, байгалийн гамшиг зэрэг аюулыг эрсдэлгүй даван туулахад бэлдэж, нэгдсэн стратеги бүхий цогц эрсдэлийн менежментийг шинэчлэн баталж, үндэсний хэмжээнд мөрдүүлнэ (90.0%, НЭМБХГ);
- 4.7.11.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой бүхий л үйл ажиллагааг төрийн хяналтад авч, уг үйл ажиллагааг зөвхөн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлүүлэх, мансуурах донтой хүнд олон улсын стандартад нийцсэн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх, мансуурах донг эрт илрүүлэх, эмчлэх, хяналтад авах, нийгэмшүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгоно (50.0%, НЭМБХГ).

Дөрөв. Дүгнэлт

1. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан эрүүл мэндийн салбарын 23 арга хэмжээний хэрэгжилтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар үнэлэхэд 86.85 хувьтай, журамд заасан шалгуураар “Үр дүн гарсан” гэж үнэлэгдлээ.

2. Нийт 6 арга хэмжээ төлөвлөсөн зорилт, үр дүнгийн шалгуур үзүүлэлтэд хүрээгүй бөгөөд хэрэгжилт хангалтгүй тул “Үр дүнгүй” гэж үнэлэгдэв. Эдгээр арга хэмжээний хувьд хэрэгжилтэд нөлөөлсөн бодит шалтгаан, нөхцөлийг тодорхойлон, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан төлөвлөх шаардлагатай байна.

3. Цаашид Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний тайлант хугацаанд арга хэмжээний хэрэгжилтийг батлагдсан зорилт, үр дүнгийн үзүүлэлттэй нягт

уялдуулан, бодитой, үнэн зөв, нотолгоонд суурилсан байдлаар тайлагнаж, тайлангийн чанарыг эрс сайжруулах шаардлагатай байна.

Тав. Зөвлөмж

1. Арга хэмжээний төлөвлөлтийн үе шатанд зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхой, хэмжигдэхүйц, үнэлэх боломжтой байдлаар тогтоож, хэрэгжилтийн явцад бодит үнэлгээ хийх нөхцөлийг бүрдүүлэх;
2. Бодлогын болон хатуу дэд бүтцийн бус арга хэмжээг хугацаатай, үр дүнд суурилсан шалгуур үзүүлэлттэйгээр баталж, хэрэгжилтийн ахицыг бодитой хэмжих боломжтой болгох;
3. Олон салбар, олон нэгж хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд байгууллага хоорондын уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулах, тухайлбал НЭМБХГ, ЭТБХГ, БТГ зэрэг холбогдох нэгжүүдийн хамтарсан арга хэмжээнд явцын хяналт тавих байнгын ажлын хэсэг байгуулах, эсхүл дундын нэгдсэн тайлагналын формат нэвтрүүлэх;
4. Тайланг үр дүнд суурилсан, давхардалгүй, нотолгоо, мэдээлэлд тулгуурласан хэлбэрээр боловсруулж хэвших, тайлагналын чанар, бодит байдлыг сайжруулах;
5. Тэргүүлэх чиглэлийн арга хэмжээнд онцгой анхаарал хандуулж, ялангуяа салбар хоорондын бодлогын уялдааг сайжруулах, шаардлагатай санхүүжилт, эрх зүйн дэмжлэгийг үе шаттайгаар нэмэгдүүлэх.

СХШУДАГ